



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/51

Алтанбулаг

Хугацаат цэргийн албаны ээлжит
татлага зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 34 дугаар зүйл, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны А/126 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 оны нэгдүгээр ээлжийн хугацаат цэргийн албаны татлагыг 04 дүгээр сарын 27-ны өдөр Сүхбаатар сумын цэрэг татлагын байранд зохион байгуулсугай.

2.2022 оны нэгдүгээр ээлжийн хугацаат цэргийн албаны татлагад 1997 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2004 оны 05 дугаар сарын 10-ны хооронд төрсөн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудыг хамруулсугай.

3.Цэрэг татлагын анкетыг 18-25 насны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн тус бүрд бүртгэн шивж, "Байгууллагын баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалт"-ын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн хадгалахыг 1 дүгээр багийн Засаг дарга (Э.Зориг), 2 дугаар багийн Засаг дарга (Н.Мөнхзул), 3 дугаар багийн Засаг дарга (Г.Мөнхболд) нарт даалгасугай.


4.Эрүүл мэндийн үзлэгт орж байгаа иргэдэд Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан эрүүл мэндийн үндсэн /Цусны ерөнхий, шээсний ерөнхий, биохимийн /сахар, АСАТ, АЛАТ, креатинин, мочевин/ элэгний В,С вирус илрүүлэх, ДОХ, тэмбүүгийн, Ковид-19-ийн түргэвчилсэн шинжилгээг бүрэн хийлгэж, анкетад нь хавсаргах, сумын эрүүл мэндийн төвийн эмчийг цэрэг татлагын байранд очиж хамтран ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (У.Энхбямба)-д даалгасугай.

5. 18-25 насны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн нэг бүрд зарлан дуудах хуудас гардуулан өгч, цэрэг татлагын байранд заасан хугацаа тогтоосон цагт бэлэн байлгах, тэдгээрийн цахим үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, гэрийн шаахай (тавчиг), 4-5 ээлжийн амны хаалт (маск)-тай, 2 хувь эрүүл мэндийн үзлэгийн анкет, 3 хувь цээж зураг зэргийн бүрэн бүрдүүлж ирүүлэхийг 1 дүгээр багийн Засаг дарга (Э.Зориг), 2 дугаар багийн Засаг дарга (Н.Мөнхзул), 3 дугаар багийн Засаг дарга (Г.Мөнхболд) нарт даалгасугай.

6. 2022 оны нэгдүгээр ээлжийн хугацаат цэргийн албаны татлагад орох залуусыг сум хооронд тээвэрлэх, тэнцсэн залуусыг сум, аймгаас үдэн гаргах үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг Алтанбулаг сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч (Г.Энхтүвшин)-д үүрэг болгосугай.

7.Гадаадад оршин суугаа Монгол Улсын 18-25 насны иргэдийн хилээр гарсан лавлагааг Хил хамгаалах ерөнхий газраас авч ирэхийг багийн Засаг дарга нарт хариуцуулсугай.

ДАРГА



Н.ОТГОНЦОГТ